



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 92

Мандалговь

Нүүрс тээвэрлэлтийн үйл
ажиллагааг түр зогсоох тухай

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 62 дугаар зүйлийн 62.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.2."л", 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.4, 20.1.13, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан "Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам"-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Өмнөговь аймгийн Цогтцөций сумаас Говьсүмбэр аймаг хүртэлх Тавантолгойн нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг Дундговь аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч буй Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 05 сарын 03-ны өдрийн 134 дүгээр тогтоолоор батлагдсан улсын чанартай авто замаас бусад орон нутгийн чанартай авто замаар тээвэрлэхийг хориглосугай.

Хоёр. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ), Цагдаагийн газар (Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Автотээврийн төв (Ц.Бямбацогт), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Н.Гантулга), Их газрын чулуу тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа (Р.Баттүвшин), Баянжаргалан сумын Засаг дарга (Т.Цэвэлмаа), Өлзийт сумын Засаг дарга (А.Эрдэнэбат), Гурвансайхан сумын Засаг дарга (Л.Өлзийбат), Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох) нарт тус тус даалгасугай.

Гурав. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 48 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  С.СҮХБААТАР





**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 93

Мандалговь

Г

Нэрэмжит болгох тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.12 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

Нэг: Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийг тус сумын харьяат нэрт эрдэмтэн сэтгүүлч, орчуулагч, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн Бархасын Банзрагчийн нэрэмжит болгосугай.

Хоёр: Б.Банзрагчийн түүхэн гавьяаг залгамж хойч үедээ түгээн дэлгэрүүлж, олон нийтэд сурталчлан алдаршуулахад идэвх санаачлагатай ажиллахыг Гурвансайхан сумын Засаг дарга (Л.Өлзийбат) - д үүрэг болгосугай.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

